



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.06 № 03/48 ХАТ-ГАТ/2013/08-СТАТЭС

Г Төсвийн орлого болгох тухай Г

Сангийн сайдын төсвийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 213 дугаар тогтоол, Сангийн сайдын мөн өдрийн 297 дугаар тушаалаар Засгийн газрын үнэт цаасыг олон улсад сурталчлах, худалдан борлуулахтай холбогдон гарсан зардал 5,376,858.0 ам.доллартай тэнцэх эх үүсвэрийг Засгийн газрын үнэт цаасны хүүгийн зардлаас нөхөн санхүүжүүлэхээр шийдвэрлэсний дагуу дээрх хөрөнгийг зарцуулсан ба зарцуулаагүй хөрөнгийн үлдэгдэл 379,305.420 ам.долларыг улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т " төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй"-д төлбөрийн акт тогтооно гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын үнэт цаасыг олон улсад сурталчлах, худалдан борлуулахтай холбогдон гарсан зардлын хэмнэлт 379,305.420 ам.долларыг 2013 оны 5 дугаар сарын 25-ны дотор Төв төрийн сан дах Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд төвлөрүүлэх
2. Дээрх төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын
Ахлах аудитор

Ч.Болд

УХА0122

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

Сангийн яамны ТНБДарга

Х.Ганцогт
Санхүүгийн бодлого, өрийн
удирдлагын газрын дарга
Т.Доржханд

070224